

Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний сэцэлсэн шастир

8-р анги

Хичээлийн зорилго

Эртний туульсын найраглалыг уншиж,
мэдэрч хүлээн авах, найраглалын
бүтэц, хэлбэрийг задлан шинжлэх

Туульсын зохиол

- ❖ Туульсын зохиолын төрөл нь хүний аж амьдралыг тал бүрээс нь тусган зан төрх, нөхцөл байдлыг дэлгэрэнгүй чөлөөтэй өрнүүлж дүрсэлдэг, үйл явдалтай үргэлжилсэн, шүлэглэсэн зохиолуудыг нийтэд нь багтаан хэлдэг.
- * Туульсын зохиолыг хэмжээ, агуулгын багтаамж ,зохиомжийн хэлбэр, байгуулалт, дүрийн системийг харгалзан их туульс / роман / дунд / тууж, туульсын найраглал/ , бага / өгүүллэг, туурь, домог, үлгэр, шог яриа/ 3 хэлбэрт хувааж үздэг.
- * **Эртний түүхэн зохиолын нэгэн зүйлийг шастир гэдэг .**

- ❖ Монголчуудын түүхийн сурвалж бичгийн нэлээд нь 17-18 дугаар зуунд хамаардаг.
- ❖ Зохиолд гарч буй үйл явдал нь Чингис хааны 50 насны сүүдэр хүрсэн шарагчин хонин жил буюу 1211 онд Хэрлэн голын хөвөөнд болсон тухай түүхчид тэмдэглэсэн байдаг.
- ❖ “ Чингисийн 9 өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шастир “ гэдэг зохиол нь Лувсанданзаны “ Алтан товч”, Рашпунцагийн “Болор эрих”, 1925 онд нийтлэгдсэн “Чингис хаан цадиг” зэрэг судар бичгийн дотор уламжлагдан хадгалагдаж ирсэн.

1. Зохиолоо уншаад, үгийн утгыг тодруулъя

Өрлөг – Цэрэг удирдсан гавьяа байгуулсан их жанжны цол

Сэцлэх – Оюун ухаанаа уралдуулах

Шастир – түүхэн бичвэр

Үлдэх- хөөх

Исэл- сайн

Зарлиг- Улсын дээд эрхийг баригч хүнээс гаргасан шийдвэр

Цулгуй- амттан шимттэн ховор хомс

Түшмэл- Төрийн албан хэргийг таслан тогтооход оролцох эрх мэдэл бүхий тушаалтан

Чуулган- Алив ажлыг зөвлөлдөхийн тулд хуран чуулсан цуглаан

Тахих- архи, цай тэргүүтний дээжийг тэнгэр бурхандаа өргөх зан үйл

Таван өнгө, дөрвөн харь улс- Хар төвөд, шар сартуул, цагаан солонгос, улаан хятад, хөх монгол хэмээн 5 өнгөөр 5 улсыг, Монголоос бусад 4 орныг харь улс хэмээн нэрлэжээ.

2. Хам сэдэв

Бичвэр дотор үзүүлсэн орон, цаг болоод нөхцөл байдлыг хам сэдэв гэнэ.

Хам сэдэв нь нийгэм, түүх, соёл, улс төр, шашин, шинжлэх ухааны нөхцөл байдлын онцлогийг харуулдаг. Зохиолын хам сэдвийн тусламжтайгаар өөр өөр цаг үе, соёлт нийгмийг танин мэдэхээс гадна дайн тулаан, хайр сэтгэл, шашин суртахууны тухай мэдэж авдаг юм.

Зохиолын хам сэдвийн хүрээнд санаа бодлоо илэрхийлэх

Нийгмийн хам сэдэв

- Нийгмийн байдал
- Нийгмийн анги давхарга, зэрэг зиндаа, , давхарга – эзэн хаан , албат тэгш эрхтэй байх
- Ёс суртахуун - харилцаа

Түүхийн хам сэдэв

- Түүхэн он цаг - 13-р зуун
- Түүхэн газар ,орон
- Түүхэн улс
- Түүхэн үйл явдал
- Түүхэн хүмүүс

Соёлын хам сэдэв

- Ёс заншил
- Хурим найр, хурал чуулган
- Идээ ундааны хэрэглээ, соёл

3. Зохиолын сэдэв утга санааг бүрдүүлэхийн тулд сэдвийг өргөжүүлснийг задлан шинжилж ярилцъя

1. Зохиолд юуны тухай өгүүлсэн байна вэ?
2. Зохиолд эв найрамдалтай байхыг чухалчилсан санаа байна уу?
3. Зэрэг, зиндаа, анги давхаргын ялгаагүйгээр хүн бүр өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэхийг харуулж байгаа хэсгийг эхээс олж тайлбарлаарай.
5. Зохиогч зохиолоор дамжуулан уншигчдад юуг хэлэхийг зорьсон бэ?
6. Архины гэм хороос гадна өөр ямар санааг чухалчлан хөндсөн бэ? Зохиолоос эш татан батална уу?

Зохиолын сэдэв утга санааг бүрдүүлэхийн тулд сэдвийг өргөжүүлснийг задлан шинжлэх

. Архины хэрэглээг хэн юу гэж үзэв?

№	Архийг хэрэглэх нь зөв гэж үзсэн өрлөгүүд	Архины хэрэглээг буруу гэж үзсэн өрлөгүүд
1	Сорхон шар	Мухулай
2	Чуу мэргэн	Боорчи
3	Зэлмэ	Зэв
4	Хар Хиру	Борохул
5		

6 Хэн архийг тохирлуулж хэрэглэх ёстой гэж үзсэн бэ? Эш татан батлаарай.

Өнчин хөвгүүн: ...Балай их ууваас өвчин биш үү
Бага зэрэг ууваас жаргал биш үү....

4. Зохиолийн уран дүрслэл

Уран зохиолын найруулгад дүрслэлийг уран яруу болгохын тулд үгийн утгыг шилжүүлэн хэрэглэхийг дүрслэх ур маяг гэдэг. Үүнд: адилтгал, төлөөлөл, тойруулал, багасгал, өгтлөл, егөөдөл, амьшуулал, хүншүүлэл, хэтрүүлэл зэрэг арга ордог.

Сурах бичгээс хэсэглэл 1,2 ыг уншаад, зохиолын эшлэл, уран дүрслэлийн арга хэрэглүүр болон тухайн эшлэлийг хэн хэлснийг тодруулъя

№	Эшлэл	Уран дүрслэлийн ямар аргыг хэрэглэсэн бэ?	Хэлсэн эзэн нь хэн бэ?
1	Аманд орохдоо алтан шумуул мэт ...	Адилтгал	Боорчи
2	Сайн муу 2-ыг минь мэдүүлдэг биш үү ...	Эсрэгцүүлэн/адилтгал	Чуу мэргэн
3	...Хулгана мэт биеийг чинь хугачнам би Хурсан бүгдэд инээдэм болгоном би гэв.	Адилтгал	Чандага цэцэн
4	Хун галуу мэт дуугаа нэгтгэж Хулан тахь мэт зүсээ нийлүүлж Хурсан бүгд жаргалдан цэнгэе...	Адилтгал	Шихихутаг

5. Далд утга

- * Далд утгатай үгс болон адилтгал, бэлгэдлийг ашиглаж, зохиогчийн санаагаа нуухыг хэлнэ. Шүлгийн далд санаа нь яруу найрагчийн зохиолдоо өгүүлж буй хам сэдэвтэй холбогдон илэрнэ.

Далд утгыг тайлан тайлбарлая

№	Эшлэл	Далд утгын тайлбар
1.	Өчүүхэн хүнийг өргөж хайрлахул өсдөггүй буюу Үргэдэг морийг өргөж тэжээхүл таргалдаггүй буюу	өчүүхэн бодолтой хүнийг өргөж дэмжсэн ч нэмэргүй.
2.	Хамаг хурагсдад сэцэн үгүй гэж Хаан эзэнд чи үг айлтгах буюу	Хуран цугласан бүхнийг тэнэг гэж бодон хаан эзэнд аймшиггүйгээр үг айлтгалаа.
3.	Ихсийн зэрэгт орсон болоосой би Ер үгээ хэлээсэй би гэж байв.	эрх мэдэлтэй болоосой, чин үнэн үгээ хэлэх юмсан
4.	Аманд орохдоо алтан шумуул мэт Амнаас гарахдаа арслан заан боссон мэт	Архиний шид, гэм хорыг өгүүлсэн, сургамжилсан
5.	Үгтэй бол өч чи Хошоотой болбол холбо чи	Хэлэх үг байгаа бол хэл

Зохиолын далд утга:

- * Эзэн хаан, албат иргэн хоёр хоёулаа тэгш эрхтэй байхыг сануулсан.
- * Эзэн албатаа хүндэлж үгийг нь сонсдог байхыг илэрхийлсэн.
- * Архины гэм хорыг шүүмжилсэн, зөв зохистой хэрэглэх тухай өгүүлсэн.
- * Эв найрамдалтай байхыг чухалчилсан.

Дүрийн холбоо хамаарлаар гол ба туслах, сөрөг дүрийг судлах

Гол дүр :Үзэл бодол, үйл хэрэг , эрхэм нандин чанараараа дагуулж, асуудлын шийдлийг олж, шийдвэрийг гаргаж буй давуу хүчнийг гол дүр гэнэ.

Сөрөг дүр: Гол дүртэй бүхий л талаараа зөрчилдөж буй хүн буюу сөрөг хүсний эсрэг дүрийг хэлнэ.

Туслах дүр: Гол дүрийн үзэл бодол, үйл хэргийг дэмжин оролцож байгаа дүр.

Түүхэн дүр: Нийгмийн тодорхой түүхэн цаг үед амьдарч байсан, улс үндэстний бахархал болсон бодит хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааг уран зохиолд дүрслэн үзүүлснийг **түүхэн дүр гэнэ**.

Дүрийн холбоо хамаарлаар гол ба туслах, сөрөг дүрийг судлах

Зохиолд гарч буй түүхэн дүрүүдийн зан төрх, үг үйлдэл, үйл хэргийг орчин нөхцөлтэй нь холбон ойлгоорой.

№	Дүр	Юу хэлэв?	Сэтгэлийн ямар өнгө аясаар хандав?	Ямар үйлдэл хийв?	Үйл явдал ямар орчинд өрнөв?	Дүгнэлт: Би энэ дүрийн зан төрхийг... Ийнхүү тодорхойлж бна. Яагаад гэвэл...
1	Чингис					
	Сорхон шар					
2	Мухулай					
	Чуу мэргэн					
3	Боорчи					
	Зэлмэ					
4	Зэв					
	Хар Хиру					
5	Борохул					
	Шихихутаг					

Зохиолын орчин нөхцөл

Нөхцөл байдал:

Дүрүүдийн хоорондын харилцааны нөхцөл байдал, дүрүүдийг үзүүлсэн орон цагийн нийгэм, түүх, соёлын онцлогийг хэлнэ.

Зохиолын орчин нөхцөл нь дүрийн зан төрхийг тодорхойлоход нөлөөлж байгааг тайлбарлая

Задлан шинжлэх асуулт даалгавар

- * Зохиолын хэрэг явдал нь Монголын түүхийн аль цаг үед хамаарч байна вэ?
- * Зохиолын орчин нөхцөлийг эргэцүүлж бодоорой.

Чингис хааны амьдарч
байсан цаг үеийн нөхцөл
байдал

Түүхэн цаг үе
Соёл ахуй
Нийгмийн харилцаа

* Үйл явдал өрнөж байгаа орчин, нөхцөл нь дүрүүдийн зан төрхийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлахын тулд дараах асуултад хариулан бичээрэй.

<p>А. Зохиолын үйл явдал хэдий үед болж байгаа вэ? \Хэзээ?\</p>	<p>Б. Үйл явдал хаана, ямар орчинд өрнөж байгаа вэ? \Хаана?\</p>
<p>В. Ямар үйл явдал өрнөж байна вэ? \ Юу?\</p>	<p>Г. Уг үйл явдалд хэдэн хүн оролцсон бэ? \ хэдэн? \</p>
<p>Д. Хүмүүсийн сэтгэл хөдлөл, сэтгэлзүй ямархуу байдалтай байсан бол \ Ямар?\</p>	<p>Е. Тухайн орчинд дүрүүд үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх нөхцөл байдал бүрдсэн үү? \ орчин, нөхцөл\</p>

Дүгнэлт: Миний бодлоор үйл явдал өрнөж байгаа орчин, нөхцөл нь дүрүүдийн зан төрхийг тодруулахад,

1. Маш их нөлөөлдөг гэж ойлголоо. Яагаад гэвэл зохиолд бичсэн учраас би ингэж дүгнэж байна.
2. Зарим үед харилцан хамаардаг гэж бодож байна. Яагаад гэвэл, зохиолд бичсэн учраас би ингэж дүгнэж байна.
3. Тодорхой нөлөөл үзүүлэхгүй байх. Яагаад гэвэл..... гэх мэтээр бичээрэй.

Зохиолын шад холбоц, айзам, хэмнэлийг тайлбарлах

Зохиолын айзам хэмнэл, холбоцыг ажиглан дүгнэлт гаргаарай.

№	Айзам хэмнэлийг бүрдүүлдэг зүйлс	Жишээ, эшлэл	Дүгнэлт
1	Толгой холбоц	
2	Сүүл холбоц	Эртнээс нааш рашаан биш үү Энэ ертөнцөд жаргал биш үү Үүнээс хойш луртатгал биш үү Эдүгээ үүнийг тэвчвээс Энэ хурим цулгүй болох	
3	Яруу хэрэглүүр, уран асуулт	Балай их ууваас өвчин биш үү Бага зэрэг ууваас жаргал биш үү	
4	Мөр бадгийн доторх үеийн тоог тэнцүүлсэн байдал	Амраг нөхрөөс алгасуулдаг биш үү Алиа муу сэтгэлийг төрүүлдэг биш үү Ханилсан нөхрөөс хагацуулдаг биш үү Харгис дээрэнгүй сэтгэлийг төрүүлдэг биш үү	

Дүгнэлт

Хэдийгээр зохиолд Чингис хаан есөн өрлөгийн хамт архины сайн муу талыг шүүмжлэн хэлэлцдэг ч, нөгөө талаар өнчин хөвгүүний үгээр ард олны саруул ухаан авьяас билэг, мэдлэг чадварыг, мөн Чингис хааны хэргэм зэрэг хардаггүй, саруул ухаан, мэдлэг чадварыг үнэлдэг хосгүй хүн юм гэдгийг тодотгож өгсөн.

Түүнчлэн хаан, албат иргэн хоёр хоёулаа тэгш эрхтэй байх, эв эеийг хичээх ёстой гэсэн санааг чухалчилсан.